



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 471

Улаанбаатар хот

**“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын  
зохион байгуулалтын бүтцийн зарим нэгжийн  
нэрийг өөрчлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны ““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” 522 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан бүтцийн нэгж болох “Технологийн сургууль” гэснийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль”, “Орос сургууль” гэснийг “Ерөнхий боловсролын 19 дүгээр дунд сургууль”, “Орос цэцэрлэг” гэснийг “12 дугаар цэцэрлэг” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ